



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2017 оны 07 сарын 04-ны  
өдрийн 3752 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/86

Улаанбаатар хот


Барагшуныг түүж бэлтгэх,  
экспортлохыг түр хугацаагаар  
хориглох тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэл, Монгол эрдэмтэн судлаачдын 2009 оны "Монгол Алтайн барагшуны тархац, гарал үүсэл, химийн бүрдэл" судалгааны тайланг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол орны барагшуны тархац, нөөц хомсдож байгааг харгалзан барагшуныг түүхийгээр болон хагас боловсруулсан түүхий эд, судалгаа, шинжилгээний сорьц, дээжийг 5 кг-аас дээш хэмжээгээр гадаад улсад гаргах зорилгоор түүж бэлтгэх, боловсруулах, экспортлохыг 5 жилийн хугацаагаар хориглосугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан орон нутагт холбогдох арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/-т тус тус даалгасугай.

САЙД



Д.ОЮУНХОРОЛ

МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ  
ХУУЛБАР ҮНЭН  
САЙДЫН ДАРГА  
407/811  
2017 оны 04 сарын 14-ний өдөр  
Т.Нямсүрэн